

ᠪᠠᠶ᠋ᠠᠨ-ᠥᠯᠭᠢᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ
ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠳᠢᠲᠤᠨ ᠭᠠᠰᠠᠷ

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ
НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН КОД: БӨА-2026/002/НА-СТА-ТЕЗ

**ӨЛГИЙ ХОТ
2026 ОН**

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгт, хавсралт, графикийн товъёог	4
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	5-6
БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ.....	7
1.1 Орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөлт	7-8
1.2 Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлт	8-10
1.3 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт	100
1.3.1 Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөлт	100-13
1.3.2 Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын орон тооны төлөвлөлт.....	...13
1.3.3 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт.....	14
1.3.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт.....	14-15
1.2.5 Замын сангийн төлөвлөлт.....	15
БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	16
2.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ.....	16
2.1.1 Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл.....	16
2.1.2 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл	17-18
2.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ.....	19
2.2.1 Төсвийн зарлагын гүйцэтгэл	19-24
2.2.2 Аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн байгууллагуудын орон тооны гүйцэтгэлийн талаар.....	24-25
2.2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.....	25-26
2.2.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл.....	..26
2.2.5 Замын сангийн гүйцэтгэл.....	.27
БҮЛЭГ 3. ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ХЭРЭГЖИЛТ	27
3.1 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшин	27-28
БҮЛЭГ 4. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР	28
4.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	28
4.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	29
ДҮГНЭЛТ:	30
ЗӨВЛӨМЖ:.....	31
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	32
ХАВСРАЛТ:	33-37

Хүснэгтийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт№1	Улсын төсвөөс олгох санхүүжилтийн төлөвлөлт	7
Хүснэгт №2	Орон нутгийн нийт орлогын төлөвлөгөө	8
Хүснэгт №3	Суурь орлогын төлөвлөлт/Орлогын төрлөөр/	9-10
Хүснэгт №4	Орон нутгийн зарлагын төлөвлөгөө	11
Хүснэгт №5	Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагын төлөвлөлт	12
Хүснэгт №6	Орон тооны төлөвлөлт	13
Хүснэгт№7	Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл	16
Хүснэгт№8	Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл	17
Хүснэгт№9	Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл / аймаг, сумаар/	18
Хүснэгт №10	Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл	19
Хүснэгт№11	Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг байгууллагаар	22
Хүснэгт №12	Аймгийн Засаг даргын ерөнхий дансны гүйцэтгэл	23
Хүснэгт №13	Орон нутгийн төсвийн байгууллагуудын орон тооны гүйцэтгэл	24
Хүснэгт №14	Батлагдсан орон тоог хэтрүүлсэн байгууллагууд	24-25

Хавсралтын товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт №1	Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	34-36
Хавсралт №2	Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2025 оны нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл	37-38

Графикийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
График №1	Суурь орлого /өмнөх онтой харьцуулсан/	9
График №2	Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөлт	10

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай А/146, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийв.

Аудитын зорилт:

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны орон нутгийн нэгдсэн төсвийн төлөвлөлт үндэслэлтэй эсэх, гүйцэтгэлийг үнэн зөв нэгтгэж тайлагнасан эсэхийг шалгаж, дүгнэлт зөвлөмж боловсруулан, дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны орон нутгийн төсвийг бодитой төлөвлөж, бүрдүүлсэн эсэх;
2. Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны орон нутгийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан эсэх;
3. Аймгийн ТЕЗ-ийн 2025 хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;
4. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Татварын хэлтсийн аудитад хамрагдах хэсгийн татварын төлөвлөгөө, тайлан, Сангийн яамнаас Баян-Өлгий аймгийн 2025 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад холбогдох материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, МУЕА-ын 2021 оны А/71 тушаал “Заавар аргачлал батлах тухай” журмын аргачлалыг баримтлан аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон бусад холбогдох хэлтсүүдийн албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, нэгтгэх, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, асуудын шинжилгээ, горимын дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Татварын багц хуулиуд, аймаг, сумын ИТХ-ын тогтоолууд, аймгийн ТЕЗ-ийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Женисбек хянан удирдаж, чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл, аудитор М.Айнур, Х.Еркебулан нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг 2025 оны 04 дүгээр сарын 01-ээс 04 дүгээр сарын 20-ыг хүртэл хугацаанд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл:

Аудитын ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.1 Орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөлт

Тус аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 10,298.2 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 4,638.7 сая төгрөгөөр бууруулж тодотгож баталсан байна

УИХ-аас Баян-Өлгий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 29,659.7 сая төгрөгөөр, ОНХНС-гаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 14,034.3 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар орсон өөрчлөлтөөр тус аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 10,298.2 сая төгрөгөөр бууруулж 19,361.5 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 4,638.7 сая төгрөгөөр бууруулж 9,395.6 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №1 **Улсын төсвөөс олгох санхүүжилтийн төлөвлөлт** (сая төгрөг)

Үзүүлэлт	2024 он	2025 оны		Зөрүү
		Баталсан	Тодотгосон	
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	22,080.6	29,659.7	19,361.5	-10,298.2
ОНХ-ийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг	11,949.5	14,034.3	9,395.6	-4,638.7
Тусламж санхүүжилтийн орлогын нийт дүн	34,030.1	43,694.0	28,757.1	-14,936.9

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтөд хийсэн аудитын судалгаа

Өмнөх онтой харьцуулахад улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 2,719.1 сая төгрөгөөр, ОНХНС-гаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 2,553.9 сая төгрөгөөр буурсан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 8.4.31-д заасан хугацаанд боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн байна. Сангийн яамнаас татварын орлогын төлөвлөгөөг 32,726.1 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,410.0 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна. Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн 29,659.7 сая төгрөг, ОНХНС-гаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 14,034.3 сая төгрөгийг оруулж тооцоход тус аймгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 77,830.1 сая төгрөг байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” 30 дугаар тогтоолоор татварын орлогын төлөвлөгөөг 2,840.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,675.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн төсвийн нийт орлогыг 82,337.7 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №2 **Орон нутгийн нийт орлогын төлөвлөгөө**

(сая төгрөг)

Үзүүлэлт	Сангийн яамны хянаж ирүүлсэн	Аймгийн ИТХ-ын 2024.12.26-ны 30-р тогтоол	УИХ-аас баталсан тодотгол	Аймгийн ИТХ-ын 2025.09.11-ний 58-р тогтоолоор баталсан тодотгол	Сумын ИТХ-аар баталсан дүнг нэмсэн дүнгээр	Зөрүү
	1	2	4	5	6	/6-2/
Татварын орлого	32,726.10	35,566.10	32,238.10	34,538.50	36,644.10	1,078.00
Татварын бус орлого	1,410.00	3,085.60	1,410.00	5,393.40	5,523.20	2,437.60
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	29,659.70	29,659.70	19,361.50	19,361.50	19,361.50	-10,298.20
ОНХ-ийн сангийн шилжүүлэг	14,034.30	14,026.30	9,395.60	9,395.60	9,395.60	-4,638.70
Үндсэн үйл ажиллагааны орлого					2,059.40	2,059.40
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0	0			5,785.50	5,785.50
Нийт орлогын дүн	77,830.10	82,337.70	62,405.20	68,689.00	78,769.30	-3,568.40

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтөд хийсэн аудитын судалгаа

Аймгийн ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн “Аймгийн 2025 оны төсвийн тодотгол батлах тухай” 58 дугаар тогтоол дээр сумуудын ИТХ-ын тогтоолоор баталсан орлогыг нэмж тооцоход татварын орлогыг 36,644.1 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 5,523.2 сая төгрөгөөр, ОНХС-ийн шилжүүлгээс авах санхүүжилтийг 9,395.6 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих дүнг 2,059.4 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 5,785.5 сая төгрөгөөр буюу нийт орлого, эх үүсвэр улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийн хамт 78,769.3 сая төгрөг байхаар тодотгож баталсан байна.

1.2 Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлт

Орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамны хянасан дүнг 9,631.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн суурь орлогын төсвийн төслийг Сангийн яаманд 18,963.4 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлснийг 34,136.1 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.


Аймгийн ИТХ-ын 2024 оны 30 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг 4,515.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 38,651.6 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар орсон өөрчлөлтөөр тус аймгийн орон нутгийн суурь орлогыг анх хянаж ирүүлсэн дүнгээс 488.0 сая төгрөгөөр бууруулж тодотгож баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 58 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг анх баталснаас 1,280.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 39,931.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумуудын ИТХ-ын тогтоолоор нэмж баталсныг оруулж тооцоход аймгийн 2025 оны суурь орлогын нийт төлөвлөгөө 42,167.3 сая төгрөг байна. Үүнээс 36,644.1 сая төгрөгийг татварын орлогоос, 5,523.2 сая төгрөгийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

График№1



Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулахад 2,341.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Аймгийн төсөвт орох орлогыг 2,327.1 сая төгрөгөөр, сумуудын төсөвт орох орлогыг 14.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Орон нутгийн суурь орлогын төлөвлөгөөг орлогын нэр төрлөөр авч үзэхэд:

Хүснэгт №3 Суурь орлогын төлөвлөлт/Орлогын төрлөөр/ (сая төгрөг)

Орлогын төрөл	Сангийн яамны хянасан суурь орлого	Аймгийн ИТХ-ын 2024.12.26-ны 30-р тогтоол	МУ-ын 2025 оны төсөвт хийсэн тодотгол	Аймгийн ИТХ-ын 2025.09.11-ний 58-р тогтоолоор баталсан тодотгол	Сумуудын ИТХ-ын тогтоолоор баталсныг нэмсэн дүнгээр	Зөрүү	
						/e-b/	/e-a/
	a	b	c	d	e		
СУУРЬ ОРЛОГО	34,136.1	38,651.6	33,648.1	39,931.9	42,167.3	3,515.7	9,631.2
УРСГАЛ ОРЛОГО	34,136.1	38,651.6	33,648.1	39,931.9	42,167.3	3,515.7	9,631.2
ТАТВАРЫН ОРЛОГО	32,726.1	35,566.1	32,238.1	34,538.5	36,644.1	1,078.1	5,518.1
Орлогын албан татвар	27,040.0	29,147.3	26,770.0	28,643.8	30,417.1	1,269.8	4,977.1
ХАОАТ	28,640.0	30,747.3	28,370.0	31,079.1	32,852.4	1,269.8	4,977.1
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	23,210.0	25,003.3	22,940.0	25,003.3	26,131.2	1,127.9	2,921.24
Үйл ажиллагааны орлого	550.0	550.0	550.0	550.0	838.8	288.8	288.84
Хөрөнгийн орлого	4,230.0	4,344.0	4,230.0	4,675.8	4,932.4	588.4	702.37
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	650.0	850.0	650.0	850.0	950.0	100.0	300.00
ХХОАТ-ын буцаан олголт	(1,600.0)	(1,600.0)	(1,600.0)	(2,435.4)	(2,435.4)	(835.4)	(835.37)
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1,310.0	1,330.0	1,100.0	1,100.0	1,100.0	(230.0)	(210.00)
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1,310.0	1,330.0	1,100.0	1,100.0	1,100.0	(230.0)	(210.00)
Хөрөнгийн татвар	1,629.0	1,629.0	1,629.0	1,729.0	1,943.1	314.1	314.1
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	517.0	517.0	517.0	517.0	523.0	6.0	6.00
Бууны албан татвар	60.0	60.0	60.0	60.0	60.0	-	-
Малд ногдуулах албан татвар					208.1	208.1	208.10
АТӨЯХАТ	1,052.0	1,052.0	1,052.0	1,152.0	1,152.0	100.0	100.00
Бусад татвар	735.0	831.0	735.0	855.0	899.3	68.3	164.3
Улсын тэмдэгтийн хураамж	650.0	746.0	650.0	770.0	772.5	26.5	122.52
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	55.0	55.0	55.0	55.0	92.2	37.2	37.24
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	30.0	30.0	30.0	30.0	34.5	4.5	4.50
Бусад татвар						-	-
Газрын төлбөр	709.0	709.0	709.0	709.0	704.0	(5.0)	(5.0)
Газрын төлбөр	609.0	609.0	609.0	609.0	604.0	(5.0)	(5.00)
Дуудлага худалдаа	100.0	100.0	100.0	100.0	100.0		

Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,303.1	1,919.8	1,295.1	1,501.7	1,580.7	(339.1)	277.6
Ойн нөөц ашигласны төлбөр	48.0	48.0	48.0	48.0	44.0	(4.0)	(4.00)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,217.1	1,833.8	1,217.1	1,415.7	1,498.7	(335.1)	281.64
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	38.0	38.0	30.0	38.0	38.0	-	-
II.Татварын бус орлого	1,410.0	3,085.6	1,410.0	5,393.4	5,523.2	2,437.6	4,113.2
Хүүгийн орлого							
Торгуулийн орлого	1,100.0	2,080.6	1,100.0	2,120.6	2,233.1	152.5	1,133.07
Төсөвт газрын өөрийн орлого	50.0	195.0	50.0	65.0	65.0	(130.0)	15.00
Бусад нэр заагдаагүй орлого	260.0	810.0	260.0	3,207.9	3,225.1	2,415.1	2,965.10

Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор баталсан төсөвт хийсэн судалгаа

Орон нутгийн суурь орлогын тодотгосон төлөвлөлтийг анх баталсан төсөвтэй харьцуулж судалж үзэхэд:

Татварын орлогыг анх баталснаас 1,078.1 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 2,437.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгож баталсан байна.

Татварын орлогоос ХХОАТ-ыг 1,269.8 сая төгрөгөөр, хөрөнгийн татварыг 314.1 сая төгрөгөөр, бусад татварыг 68.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 230.0 сая төгрөгөөр, газрын төлбөрийг 5.0 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөрийг 339.1 сая төгрөгөөр тус тус бууруулж тодотгож баталсан байна.

Татварын бус орлогоос торгуулийн орлогыг 152.5 сая төгрөгөөр, бусад нэр заагдаагүй орлогыг 2,415.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, төсөвт газрын өөрийн орлогыг 130.0 сая төгрөгөөр бууруулж тодотгож баталсан байна.

1.3 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ


1.3.1 Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөлт

Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөөг Сангийн яамны хянаж ирүүлснээс 14,981.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна

Аймгийн ИТХ-ын 2024 оны 30 дугаар тогтоолоор төсвийн нийт зарлагын төлөвлөгөөг Сангийн яамны хянаж ирүүлсэн дүнгээс 4,523.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 68,311.4 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар орсон өөрчлөлтөөр тус аймгийн орон нутгийн зарлагыг анх баталсан дүнгээс 10,778.3 сая төгрөгөөр бууруулж 53,009.6 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

График№2



Аймгийн ИТХ-ын 2025 оны 58 дугаар тогтоолоор төсвийн нийт зарлагыг 59,293.4 сая төгрөгөөр баталсан ба сумуудын ИТХ-ын тогтоолоор баталсан тодотгосон төсвийг нэмэхэд 78,769.3 сая төгрөг байна. /Хавсралт №1/

Хүснэгт №4 Орон нутгийн зарлагын төлөвлөгөө

(сая төгрөг)

Үзүүлэлт	Сангийн яамны хянасан суурь	Аймгийн ИТХ-ын 2024 оны 12.26-ны 30 дугаар тогтоол	МУ-ын 2025 оны төсөвт хийсэн тодотгол	Аймгийн ИТХ-ын 2025 оны 58 дугаар тогтоолоор баталсан тодотгол	Сумуудын ИТХ-ын тогтоолоор баталсныг нэмсэн дүнгээр	Зөрүү	
А	1	2	3	4	5	/2-1/	/5-2/
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,787.8	68,311.4	53,009.6	59,293.4	78,769.2	4,523.6	10,457.8
УРСГАЛ ЗАРДАЛ	57,169.6	60,228.2	47,298.4	53,003.0	58,784.4	3,058.6	-1,443.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,462.6	59,583.3	46,610.6	52,541.9	57,045.5	3,120.7	-2,537.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,100.4	27,290.6	23,018.4	23,063.6	23,146.4	3,190.3	-4,144.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,044.6	2,889.4	2,907.6	2,692.3	2,938.1	-155.2	48.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,632.8	19,221.6	16,049.4	17,844.9	17,794.8	-411.2	-1,426.8
Хангамж, бараа материалын зардал	618.6	682.3	444.4	690.1	951.5	63.7	269.2
Нормативт зардал	262.9	287.1	229.5	288.6	290.1	24.2	3.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1619.1	852.9	810.9	747.9	930.4	-766.2	77.5
Томилот, зочны зардал	231.3	313.8	115.6	302.0	376.2	82.5	62.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,318.4	3,707.1	2,484.3	3,096.1	3,099.7	-611.3	-607.4
Бараа үйлчилгээний бусад зардал	2,634.60	4,338.5	550.5	3,816.4	7,518.3	1,703.9	3,179.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	707.00	644.9	687.8	461.1	1,738.9	-62.1	1,094.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,618.20	8,083.2	5,711.2	6,290.4	19,984.8	1,465.0	11,901.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	63,787.8	68,311.4	53,009.6	59,293.4	78,769.2	4,523.6	10,457.8
Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,737.8	68,116.4	52,959.6	59,228.4	70,924.4	4,378.6	2,808.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,737.8	68,116.4	52,959.6	59,228.4	61,528.8	4,378.6	-6,587.6
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих					9,395.6	0.0	9,395.6
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	50.0	195.0	50	65.0	2,059.4	145.0	1,864.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50.0	195.0	50	65.0	2,059.4	145.0	1,864.4
Урьд оны үлдэгдлээс					5,785.50	-	5,785.5

Эх сурвалж: Аудитын судалгаа

Цалингийн зардлыг бууруулж төлөвлөснийг судалж үзэхэд:

Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн албан хаагч нарын орон нутгийн нэмэгдэлд 4,174.9 сая төгрөг төлөвлөснийг 2,649.8 сая төгрөгөөр бууруулж 1,525.1 сая төгрөгөөр тодотгож баталсан.

Аймгийн ЗДТГ-т 1,039.5 сая төгрөгөөр, ИТХ-д 20.5 сая төгрөгөөр, Байгаль орчны газарт 39.5 сая төгрөгөөр, Орон нутгийн өмчийн газарт 46.8 сая төгрөгөөр, МҮОНРТ-ийн Баян-Өлгий дахь салбарт 12.9 сая төгрөгөөр, Асрамжийн газарт 4.7 сая төгрөгөөр бууруулж, Сум дундын ойн ангид 13.6 сая төгрөгөөр, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албад 27.0 сая төгрөгөөр, Худалдан авах ажиллагааны газарт 5.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Засгийн газрын шийдвэрээр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн жагсаалтад Архивын хэлтэс нэмэгдэж, төсвийн

тодотголоор цалингийн зардалд 245.1 сая төгрөг баталсан байна.

Аймгийн 2025 оны анх баталсан төсөвт аймгийн Засаг даргын багцад байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,828.8 сая төгрөг төлөвлөсөн ба төсвийн тодотголоор дахин хянаж бууруулсан байна.

ЕБС, СӨБ-ын байгууллага, Сагсай сумын ЭМТ, аймгийн ХДТ зэрэг байгууллагуудын тогтмол зардлын төсвийг нийтдээ 646.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, сумын Соёлын төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг, БТСГ, Мэргэжлийн боловсролын сургууль, Номын сан, Музей, Асрамжийн газар зэрэг байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг нийтдээ 230.2 сая төгрөгөөр бууруулсан байна.

Төсвийн тодотголоор бараа үйлчилгээний бусад зардлын төсвийг анх баталснаас 522.1 сая төгрөгөөр бууруулсан байна.

Сумуудын ИТХ-ын тогтоолоор бараа үйлчилгээний зардлын төсвийг анх баталснаас 3,179.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Энэ нь сумуудын ИТХ-ын тогтоолоор баталсан сум хөгжүүлэх сангийн төсөв байна.

Хүснэгт №5 Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагын төлөвлөлт

(сая төгрөг)

Үзүүлэлт	Баян-Өлгий аймаг 2025 он				Тодотгол /Сумуудын нэмж баталсан дүнгээр/	Зөрүү
	Сангийн яамны хянасан дүн	Анх батлагдсан	СЯ-ны Тодотгол	Аймгийн ИТХ-ын Тодотгол		
Б	1	2	3	4	5	6=5-2
ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар						
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО	34,136.1	38,651.6	33,648.1	39,931.9	59,404.5	20,752.8
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	34,136.1	38,651.6	33,648.1	39,931.9	59,404.5	20,752.8
УРСГАЛ ОРЛОГО	34,136.1	38,651.6	33,648.1	39,931.9	42,167.3	3,515.6
Татварын орлого	32,726.1	35,566.1	32,238.1	34,538.5	36,644.1	1,078.0
Татварын бус орлого	1,410.0	3,085.6	1,410.0	5,393.4	5,523.2	2,437.6
ХӨРӨНГИЙН ОРЛОГО					9,395.6	9,395.6
ӨМНӨХ ОНЫ ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ					5,652.2	5,652.2
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО					2,189.3	2,189.3
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА	63,787.8	68,311.4	53,009.6	59,293.5	78,766.0	10,454.6
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,787.8	68,311.4	53,009.6	59,293.5	78,766.0	10,454.6
УРСГАЛ ЗАРДАЛ	57,169.6	60,228.2	47,298.4	53,003.1	58,781.2	-1,447.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,462.6	59,583.3	46,610.7	52,542.0	57,045.5	-2,537.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	707.0	644.9	687.8	461.1	1,735.7	1,090.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,618.2	8,083.2	5,711.2	6,290.4	19,984.8	11,901.6
УРСГАЛ ТЭНЦЭЛ	23,033.6	-21,576.6	-13,650.4	-13,071.1	-16,613.9	4,962.6
НИЙТ ТЭНЦЭЛ	29,659.7	-29,659.7	-19,361.5	-19,361.5	-19,361.5	10,298.2

Эх сурвалж: Аудитын судалгаа

Баян-Өлгий аймгийн орон нутгийн төсвийн орлого, зарлагын нийт тэнцэл -19,361.5 сая төгрөг ба улсын төсвийн дэмжлэгээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөнд дараах залруулга хийгдлээ.

Залруулсан алдаа:

- Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөнд Засгийн газрын урсгал шилжүүлгийг 3.3 сая төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр талд урьд оны үлдэгдлээс санхүүжих үлдэгдлийг 68.3 сая төгрөгөөр дутуу, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих дүнг 65.0 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залруулсан.

1.3.2 Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын орон тооны төлөвлөлт

Төсвийн тодотголоор орон нутгийн төсвийн байгууллагуудын анх батлагдсан нийт орон тоог 27 орон тоогоор бууруулж баталсан байна

Сангийн яамнаас аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын орон тооны хязгаарыг 580 орон тоогоор хянаж ирүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 30 дугаар тогтоолоор аймгийн ТЕЗ-ийн харьяа 37 байгууллагын орон тоог 691-ээр баталж, аймгийн ИТХ-ын 2025 58 дугаар тогтоолоор 121 орон тоогоор бууруулж 570 орон тоогоор баталсан байна. Сумуудын ИТХ-ын тогтоолоор баталснаар тайлант оны аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын батлагдсан нийт орон тоо 664 байна.

Хүснэгт№6

Орон тооны төлөвлөлт

Аймгийн ТЕЗийн харьяа орон нутгийн байгууллагууд	Аймгийн ИТХ-ын 2024 оны 30 дугаар тогтоолоор анх баталсан	Аймгийн ИТХ-ын 2025 оны 58 дугаар тогтоолоор тодотгож баталсан	Сумуудын ИТХ-ын тогтоолоор нэмж баталсан дүнгээр	Орон тоо хассан	Орон тоо нэмсэн
	1	2	3	4=3-1	5=3-1
Аймгийн ИТХ	18	16	16	2	
Сумуудын ИТХ	46	42	46	0	
Аймгийн ЗДТГ	114	92	92	22	
Сумуудын ЗДТГ	392	320	410		18
Орон нутгийн өмчийн газар	16	6	6	10	
Сум дундын ойн анги	8	9	9		1
Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	7	9	9		2
Асрамжийн газар	11	10	10	1	
Орон нутгийн олон нийтийн радио, телевиз	20	18	18	2	
Байгаль орчны газар	45	37	37	8	
Худалдан авах ажиллагааны газар	14	6	6	8	
Архивын хэлтэс	0	5	5		5
Дүн	691	570	664	53	26

Эх сурвалж: Орон тооны төлөвлөгөөнд хийсэн аудитын судалгаа

Сумуудын ЗДТГ-уудын орон тоог 18 орон тоогоор, Сум дундын ойн анги, СХДАА-ны орон тоог 1-2 орон тоогоор нэмж, бусад байгууллагуудын орон тоог 2-

22 орон тоогоор буюу нийт 53 орон тоогоор бууруулж, шинээр байгуулагдсан Архивын хэлтэст 5 орон тоо баталсан байна.

1.3.3 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд 4,215.0 сая төгрөгийн 71 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-гаас тус аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 14,026.3 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 30 дугаар тогтоолоор ОНХНС-ийн орлогын шилжүүлгээс аймгийн ОНХС-д 5,346.1 сая төгрөг, сумуудын ОНХС-д 8,680.2 сая төгрөгийг хуваарилж баталсан байна. Аймгийн ОНХС-гийн урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 721.1 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр тус ОНХНС-гаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 4,630.7 сая төгрөгөөр бууруулж 9,395.6 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 58 дугаар тогтоолоор ОНХНС-гаас аймгийн ОНХС-д хуваарилсан орлогын шилжүүлгээс аймгийн ОНХС-д орлогын шилжүүлгийг 3,493.9 сая төгрөгөөр, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 5,901.7 сая төгрөгөөр нийтдээ 9,395.6 сая төгрөгөөр буюу анх баталснаас 4,630.8 сая төгрөгөөр бууруулж, аймгийн ОНХС-гийн урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 721.1 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 30 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3 төсөл, арга хэмжээнд 896.6 сая төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 50 төсөл, арга хэмжээнд 4,449.6 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжих 11 төсөл арга хэмжээнд 586.1 сая төгрөг, шинээр эхлэх 6 төсөл арга хэмжээнд 135.0 сая төгрөг буюу 17 төсөл арга хэмжээнд 721.1 сая төгрөг, нийт 70 төсөл, арга хэмжээнд 6,067.3 сая төгрөг баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 58 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3 төсөл, арга хэмжээнд 806.6 сая төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 51 төсөл, арга хэмжээнд 2,687.3 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр 17 төсөл арга хэмжээнд 721.1 сая төгрөг, нийт 71 төсөл, арга хэмжээнд 4,215.0 сая төгрөг баталсан байна.

1.3.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 7,151.1 сая төгрөгийн 95 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

Аймгийн ИТХ-ын 2024 оны 30 дугаар тогтоолоор аймгийн 2025 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 23 төсөл, арга

хэмжээнд 1,465.0 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр 18 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтэд 599.0 сая төгрөг, аймгийн Эрүүл мэнд, Боловсрол, соёлын салбарын засварын хөрөнгөөр шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 7 төсөл, арга хэмжээнд 193.9 сая төгрөг, шинээр хэрэгжүүлэх 39 төсөл, арга хэмжээнд 6,424.3 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр 9 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтэд 247.9 сая төгрөгийг буюу нийт 8,930.1 сая төгрөг төлөвлөж баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 58 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжих 37 төсөл арга хэмжээнд 1,453.0 сая төгрөгийг, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр 18 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтэд 599.0 сая төгрөгийг, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын их засварын 33 төсөл, арга хэмжээнд 4,837.4 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 7 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтэд 261.7 сая төгрөгийг, нийт 7,151.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж анх баталснаас 1,779.0 сая төгрөгөөр бууруулж тодотгож баталсан байна.

Аймгийн боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын засварын хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх 40 төсөл, арга хэмжээнд 5,099.1 сая төгрөг батлагдсан ба 37.7 хувийг аймаг, сумуудын сургууль, цэцэрлэгүүдийн засвар, 11.3 хувийг эрүүл мэндийн салбарын засварт 51 хувийг соёлын салбарын байгууллагын засварын арга хэмжээнд баталсан байна.

1.2.5 Замын сангийн төлөвлөлт

Замын сангийн хөрөнгөөр 2025 онд 1,311.4 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

Аймгийн ИТХ-ын 2024 оны 30 дугаар тогтоолоор Замын сангийн хөрөнгөөр шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 4 төсөл арга хэмжээнд 791.5 сая төгрөг, шинээр эхлэх 17 төсөл арга хэмжээнд 749.2 сая төгрөгийг буюу нийт 21 төсөл арга хэмжээнд 1,540.6 сая төгрөгийг баталсан байна. Замын сангийн хөрөнгөөр урьд оны үлдэгдлээс хэрэгжүүлэх 8 арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтэд 129.4 сая төгрөг баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 58 дугаар тогтоолоор Замын сангийн хөрөнгөөр шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 4 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 791.5 сая төгрөг, шинээр эхлэх 16 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 390.5 сая төгрөг, нийт 20 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд 1,182.0 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна. Замын сангийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр 8 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтэд 129.4 сая төгрөгийг баталсан байна.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Орон нутгийн нэгдсэн төсвийн төлөвлөгөөний гүйцэтгэл 86.2 хувийн биелэлттэй байна.

2.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

2.1.1 Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл

Орон нутгийн төсвийг санхүүжүүлэх нийт орлого эх үүсвэрийн төлөвлөгөө 86.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Баян-Өлгий аймгийн 2025 оны орон нутгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 78,769.3 сая төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 67,879.4 сая төгрөгийн орлого, эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг гүйцэтгэлээр 100 хувь авсан бол Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс авах санхүүжилтийг төлөвлөснөөс 85.0 сая төгрөгөөр дутуу авсан байна.

Хүснэгт №7 **Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл**

(сая төгрөг)

Үзүүлэлт	2025 оны төсвийн орлогын			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	36,644.1	34,652.3	-1,991.8	94.5
Татварын бус орлого	5,523.2	3,269.3	-2,253.9	59.1
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	19,361.5	19,361.5	0.00	100.0
Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг	9,395.6	9,310.6	-85.0	99.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	2,059.4	846.9	-1,212.5	41.1
Туслах үйл ажиллагааны орлогоос	0	75.4	75.4	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	5,785.5	363.4	-5,422.1	6.3
Нийт орлогын дүн	78,769.3	67,879.4	-10,889.9	86.2

Эх сурвалж: Орон нутгийн орлогын судалгаа

Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны нэгдсэн төсвийн нийт орлого, эх үүсвэрийн 51.1 хувийг татварын орлогоос, 4.8 хувийг татварын бус орлогоос, 28.5 хувийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээс, 13.7 хувийг Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгээс, 1.3 хувийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 0.1 хувийг туслах үйл ажиллагааны орлогоос, 0.5 хувийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,059.4 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 2,019.3 сая төгрөгийг сумуудын Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны орлогоос, 40.0 сая төгрөгийг Хот тохижуулах албаны үйл ажиллагаанаас оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр сумуудын Хоршоо хөгжүүлэх сангаас 801.6 сая төгрөгийн, Хот тохижуулах алба 40.6 сая төгрөгийн, бусад төсөвт байгууллагуудаас 4.7 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 1,277.5 сая төгрөгөөр тасарсан байна. Туслах үйл ажиллагааны орлогоос 75.4 сая төгрөгийн орлого оруулсан байна.

2.1.2 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 89.9 хувьтай гарсан байна.

Баян-Өлгий аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөө 42,167.3 сая төгрөг ба гүйцэтгэлээр 37,921.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 10.1 хувиар буюу 4,245.7 сая төгрөгөөр тасарчээ. Үүнээс: Татварын орлогын төлөвлөгөө 1,991.8 сая төгрөгөөр, татварын бус орлогын төлөвлөгөө 2,253.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №8 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл

(сая төгрөг)

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
СУУРЬ ОРЛОГО	42,167.3	37,921.5	(4,245.7)
УРСГАЛ ОРЛОГО	42,167.3	37,921.5	(4,245.7)
ТАТВАРЫН ОРЛОГО	36,644.1	34,652.3	(1,991.8)
Орлогын албан татвар	30,417.1	28,868.1	(1,549.0)
ХАОАТ	30,417.1	28,868.1	(1,549.0)
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	26,131.2	25,649.5	(481.7)
Үйл ажиллагааны орлого	838.8	664.3	(174.5)
Хөрөнгийн орлого	4,932.4	4,338.4	(594.0)
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	950.0	648.5	(301.5)
ХХОАТ-ын буцаан олголт	(2,435.4)	(2,435.4)	0.0
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1,100.0	818.3	(281.7)
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1,100.0	818.3	(281.7)
Хөрөнгийн татвар	1,943.1	2,098.0	154.9
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	523.0	782.7	259.7
Бууны албан татвар	60.0	48.0	(12.0)
Малд ногдуулах албан татвар	208.1	263.8	55.7
АТӨЯХАТ	1,152.0	1,003.6	(148.4)
Бусад татвар	899.3	794.6	(104.7)
Улсын тэмдэгтийн хураамж	772.5	655.1	(117.4)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	92.2	95.1	2.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	34.5	44.3	9.8
Газрын төлбөр	704.0	559.4	(144.6)
Газрын төлбөр	604.0	414.2	(189.8)
Дуудлага худалдаа	100.0	145.3	45.3
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,580.7	1,513.8	(66.9)
Ойн нөөц ашигласны төлбөр	44.0	39.6	(4.4)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,498.7	1,444.0	(54.7)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	38.0	30.3	(7.7)
II.Татварын бус орлого	5,523.2	3,269.3	(2,253.9)
Торгуулийн орлого	2,233.1	1,571.6	(661.5)
Төсөвт газрын өөрийн орлого	65.0	65.0	0.0
Бусад нэр заагдаагүй орлого	3,225.1	1,632.7	(1,592.4)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орлогын гүйцэтгэлийг судалж үзэхэд:

Татварын орлогоос хөрөнгийн татвар 154.9 сая төгрөгөөр давж, ХХОАТ 1,549.0 сая төгрөгөөр, ААНОАТ 281.7 сая төгрөгөөр, бусад татвар 104.7 сая төгрөгөөр, газрын төлбөр 144.6 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөр 66.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Татварын бус орлогын гүйцэтгэлийг орлогын нэр төрлөөр авч үзвэл нийт дүнгээрээ 2,253.9 сая төгрөгөөр тасарсан ба торгуулийн орлогын төлөвлөгөө 661.5 сая төгрөгөөр, бусад нэр заагдаагүй орлогын төлөвлөгөө 1,592.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Суурь орлогын гүйцэтгэлийг аймаг, сумаар нь судалж үзэхэд: Сумуудын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1,637.9 сая төгрөгөөр, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2,607.8 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №9. **Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл / аймаг, сумаар/**

(сая төгрөг)

№	Сумын нэр	2025 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
		1	2	/2-1/	2/1.
1	Алтай	938.63	949.52	10.89	101.2
2	Алтанцөгц	485.79	509.01	23.22	104.8
3	Баяннуур	822.58	833.23	10.65	101.3
4	Бугат	693.31	673.37	-19.94	97.1
5	Булган	1,194.61	1,128.76	-65.85	94.5
6	Буянт	583.67	554.61	-29.06	95.0
7	Дэлүүн	1,921.34	1,801.22	-120.12	93.7
8	Ногооннуур	1,100.56	1,181.65	81.09	107.4
9	Сагсай	1,396.59	1,526.32	129.73	109.3
10	Толбо	751.01	790.29	39.28	105.2
11	Улаанхус	1,893.16	1,983.19	90.03	104.8
12	Цэнгэл	1,918.77	2,011.58	92.81	104.8
13	Цагааннуур	1,154.84	1,133.84	-21.01	98.2
14	Өлгий	19,981.49	18,121.81	-1,859.68	90.7
15	Аймаг	7,330.94	4,723.15	-2,607.79	64.4
	БҮГД	42,167.28	37,921.54	-4,245.74	89.9
	Аймгийн дүн	7,330.94	4,723.15	-2,607.79	64.4
	Сумуудын дүн	34,836.35	33,198.39	-1,637.96	95.3

Эх сурвалж: Орон нутгийн орлогын судалгаа

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Алтай, Алтанцөгц, Баяннуур, Ногооннуур, Сагсай, Толбо, Улаанхус, Цэнгэл сумууд давуулан биелүүлж, Бугат, Булган, Буянт, Дэлүүн, Өлгий сум, Цагааннуур тосгон, аймгийн орлого тасарсан байна.

2.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Орон нутгийн төсвийн орлого тасарсантай холбоотой төсвийн зарлагын гүйцэтгэл 86.2 хувьтай гарсан байна

2.2.1 Төсвийн зарлагын гүйцэтгэл

Сангийн яамнаас зарим зардлын зарцуулах эрхийг хязгаарласан, орон нутгийн төсвийн орлого тасарснаас төсвийн зарлагын гүйцэтгэл 10,889.8 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна

Баян-Өлгий аймгийн 2025 оны орон нутгийн нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 67,879.5 сая төгрөг гарч төлөвлөснөөс 10,889.8 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №10

Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл

(сая төгрөг)

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Анх батлагдсан	Баян-Өлгий аймаг 2025 он		
			Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Б	1	2	3	4	5=4-3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70,758.5	68,311.4	78,769.3	67,879.5	-10,889.8
УРСГАЛ ЗАРДАЛ	50,974.9	60,228.2	58,784.5	52,958.5	-5,826.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,932.4	59,583.3	57,045.5	51,471.9	-5,573.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,579.5	27,290.6	23,146.4	22,193.5	-952.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,491.5	2,889.5	2,938.1	2,925.3	-12.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,686.0	19,221.6	17,794.8	16,815.7	-979.1
Хангамж, бараа материалын зардал	974.8	682.3	951.5	709.9	-241.6
Нормативт зардал	314.2	287.1	290.1	220.4	-69.7
Эд хогшил, урсгал засварын зардал	594.9	852.9	930.4	702.7	-227.7
Томилолт, зочны зардал	291.8	313.8	376.2	251.0	-125.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,674.5	3,707.1	3,099.7	2,566.3	-533.4
Бараа үйлчилгээний бусад зардал	8,325.3	4,338.5	7,518.3	5,087.1	-2,431.2
ХҮҮ	170.3	0.0	0.0	0.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,872.2	644.9	1,739.0	1,486.6	-252.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.0	0.0	1,153.6	1,025.2	-128.3
Бусад урсгал шилжүүлэг	1,872.2	644.9	585.4	461.3	-124.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,783.6	8,083.2	19,984.8	14,921.0	-5,063.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	71,333.4	68,311.4	78,769.3	67,879.5	-10,889.8
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,894.7	68,116.4	76,709.9	66,957.1	-9,752.8
Орон нутгийн төсвөөс	58,427.7	68,116.4	67,314.3	57,646.5	-9,667.8
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	11,467.1	0.0	9,395.6	9,310.6	-85.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,438.6	195.0	2,059.4	922.4	-1,137.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

Нийт зарлагын 78 хувийг урсгал зардал, 21.9 хувийг хөрөнгийн зардал, 0.1 хувийг урсгал шилжүүлэг эзэлж байна.

Батлагдсан төсөвтэй харьцуулахад бараа үйлчилгээний зардал 5,573.6 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 249.1 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 5,063.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байна.

Бараа үйлчилгээний зардлаас цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 952.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 979.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 2,431.2 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл, урамшлын зардал 952.9 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан нь:

- Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, хурлын туслах ажилтан, мэдээ, мэдээлэл хариуцсан ажилтнуудын цалин хэмнэгдсэнтэй холбоотой 144.8 сая төгрөгөөр,
- Булган сумын ерөнхий нягтлан бодогч 3 сар эзгүй байсан, бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоонд хүн авч ажиллуулаагүйтэй холбоотой 31.9 сая төгрөгөөр,
- Цэнгэл сумын ИТХ-ын Багийн иргэдийн нийтийн хурлын дарга нарын урамшуулал, нэг сарын цалин хэмнэгдсэнтэй холбоотой 34.3 сая төгрөгөөр,
- Буянт сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга 9 сар эзгүй байсан, багийн нийтийн хурлын дарга нарын цалин урамшуулал хэмнэгдсэнтэй холбоотой 48.8 сая төгрөгөөр,
- Өлгий сумын ИТХ-ын нягтлан бодогч бүрэн ажиллаагүй, нарийн бичгийн дарга нь сахилгын шийтгэлтэй байсантай холбоотой 31.3 сая төгрөгөөр,
- Аймгийн Байгаль орчны газрын цомхотголд орсон 11 хүний 11,12 дугаар сарын цалин хэмнэгдсэнтэй холбоотой 110.6 сая төгрөгөөр,
- Цэнгэл сумын ЗДТГ-аас цомхотголд орсон 5 хүний 11,12 дугаар сарын цалин, ЖДҮ хариуцсан ажилтны орон тоонд хүн ажиллаагүйтэй холбоотой 12 сарын цалин хэмнэгдэж 100.6 сая төгрөгөөр,
- МҮОНРТ-ийн Баян-Өлгий аймаг дахь салбарын жирэмсний амралт, цалингүй чөлөө авсан хоёр ажилтны оронд хүн авч ажиллуулаагүйтэй холбоотой 181.9 сая төгрөгөөр,
- Баяннуур сумын ЗДТГ цалингүй чөлөөтэй нэг ажилтны орон тоонд хүн ажиллуулаагүйтэй холбоотой 57.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн зэрэг нь цалингийн зардал төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарахад нөлөөлсөн байна.

Бараа үйлчилгээний зардлаас байр ашиглахтай холбоотой тогтмол зардал төлөвлөснөөс 979.1 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарахад аймгийн Нэгдсэн эмнэлэг 95.2 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын сургуулиуд 448.1 сая төгрөгийн, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд 160.9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төвүүд 95.6 сая төгрөгийн, Соёлын байгууллагууд 243.8 сая төгрөгийн, Мэргэжлийн боловсролын сургууль 4.6 сая төгрөгийн, Өрхийн Эрүүл мэндийн төвүүд 2.0 сая төгрөгийн, Соёл, спорт аялал жуулчлалын газар 21.9 сая төгрөгийн, Хөгжимт драмын театр 3.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан нь нөлөөлсөн байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт орон нутгийн орлогын бүрдэлтээс шалтгаалж 55.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдоогүй, оны эцэст олгосон 40.0 сая төгрөгийн санхүүжилтийг төсөвт буцаасантай холбоотой төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарчээ.

Ерөнхий боловсролын сургуулиудын тогтмол зардал 448.1 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан нь:

- Цэнгэл сумын Загаст нуур сургууль бие даасан халаалтын зуухтай бөгөөд өмнөх оны нүүрсний үлдэгдэлтэй байсан, 3 дугаар сургууль олгосон санхүүжилтийг зарцуулаагүй төсөвт хаасантай холбоотой.
- Алтай, Алтанцөгц, Буянт, Баяннуур, Бугат, Дэлүүн сумуудын ЕБ-ын сургуулиуд, Булган сумын Ёлт бага сургуульд сумын орлогын бүрдэлтээс шалтгаалж санхүүжилтийг бүрэн олгож чадаагүйтэй холбоотой байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 160.9 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан нь:

- Өлгий сумын 23 дугаар цэцэрлэгийн нэг байрны халаалтын зардлыг хамт байсан сургууль төлсөн тул халаалтын зардал хэмнэгдсэн.
- Өлгий сумын Эрдэм цогцолбор цэцэрлэг бие даасан халаалтын системтэй тул зардал хэмнэгдсэн.
- Баяннуур сумын 1, 2, Дэлүүн сумын 1, 3, Бугат сумын цэцэрлэгт санхүүжилт дутуу олгосон.
- Өлгий сумын шинээр байгуулагдсан 29, 30 дугаар цэцэрлэгийн тогтмол зардлын зарцуулах эрх нээгдээгүй тул зардал гараагүй байна.

Бараа үйлчилгээний бусад зардал төлөвлөснөөс 2,431.2 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан нь:

- Сумуудын Хоршоог хөгжүүлэх сангуудын зээлийн эргэн төлөлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс 1,111.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь голлон нөлөөлжээ.
- Замын сангийн гүйцэтгэл бага гарсан нь төсвийн орлоготой уялдуулан Сангийн яамнаас хөрөнгө оруулалттай холбоотой зардлуудыг хязгаарласантай холбоотой ба тухайн онд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийг 2026 онд он дамжуулан олгосонтой холбоотой байна.
- Худалдан авах ажиллагааны газар, Санхүүгийн хяналт, аудитын алба болон аймаг, сумын ИТХ, ЗДТГ-уудын бараа үйлчилгээний бусад зардлын зарцуулах эрхийг Сангийн яамнаас хязгаарласантай холбоотой бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Хөрөнгийн зардал төлөвлөснөөс 5,063.8 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан нь ОНХС-ийн санхүүжилт оны эцэст орсон ба Сангийн яамнаас зарцуулах эрхийг нээгээгүйтэй холбоотой байна. ОНХС-ийн санхүүжилт он дамжин олгогдсон байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан 341.9 сая төгрөгийн 18 зөрчил илэрч 12.9 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 202.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага, 126.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 заалт бүхий зөвлөмж өгсөн байна.

Орон нутгийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл 86.2 хувийн гүйцэтгэлтэй буюу 10,889.9 сая төгрөгөөр тасарсан нь төсвийн орлого, зарлагын төлөвлөлт үндэслэл муутай хийгдсэнтэй холбоотой. Байгууллагаар задалж үзэхэд:

Сумуудын ЗДТГ-ууд 92 хувийн, аймгийн ОНХС 70.6 хувийн, сумуудын ОНХС 75.8 хувийн, орон нутгийн хөрөнгө оруулалт 75.7 хувийн, сум хөгжүүлэх

сангууд 64 хувийн гүйцэтгэлтэй, аймгийн ЗДТГ 89.1 хувийн, аймгийн ИТХ 69.8 хувийн, МҮОНРТ 73.5, Замын сан 74.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

*Хүснэгт №11 Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг байгууллагаар харуулбал
(сая төгрөг)*

Байгууллага	2025 оны		Зөрүү	Биелэлт хувиар
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Сумуудын ЗДТГ	18,451.2	16,967.4	-1,483.8	92.0
Сумуудын ИТХ	3,093.7	2,689.6	-404.1	86.9
Аймгийн ОНХС	4,215.0	2,975.5	-1,239.5	70.6
Сумуудын ОНХС	8,618.7	6,529.3	-2,089.4	75.8
Орон нутгийн хөрөнгө оруулалт	7,151.1	5,416.2	-1,734.9	75.7
Сум хөгжүүлэх сан	2,019.5	1,293.3	-726.2	64.0
ЕБ-ын байгууллагуудын тогтмол зардал	7,585.0	6,708.9	-876.2	88.4
СӨБ-ын байгууллагуудын тогтмол зардал	3,753.6	3,864.8	111.2	103.0
ЭМТ-үүдийн тогтмол зардал	952.9	864.5	-88.3	90.7
Соёлын төвүүдийн тогтмол зардал	800.0	761.6	-38.3	95.2
Хот тохижуулах алба	1,425.6	1,413.2	-12.4	99.1
Аймгийн ИТХурал	1,409.2	983.9	-425.3	69.8
Аймгийн ЗДТГазар	7,268.3	6,474.4	-793.9	89.1
МҮОНРТ	825.3	606.3	-219.0	73.5
Замын сан	1,311.4	975.2	-336.2	74.4
ОНӨ -ийн газар	501.4	483.7	-17.7	96.5
Байгаль орчин аялал жуулчлалын газар	1,418.9	1,290.5	-128.4	90.9
Соёл, спорт, аялал жуулчлалын газар	417.3	417.3	0.0	100.0
Орон нутгийн халамжийн сан	58.5	58.5	0.0	100.0
Асрамжийн газар	413.5	378.2	-35.3	91.5
Ойн анги	352.1	316.4	-35.7	89.8
СХДАА	357.1	333.6	-23.5	93.4
Хөгжимт драмын театр	640.4	640.4	0.0	100.0
Нэгдсэн эмнэлэг	2,375.9	2,265.4	-110.5	95.4
ОНС музей	98.9	94.5	-4.4	95.6
Номын сан	56.1	56.1	0.0	100.0
Аймгийн Засаг дарга	2,152.2	1,990.8	-161.4	92.5
МСҮТ-ОН	375.9	372.5	-3.4	99.1
насан туршийн боловсрол	10.0	7.0	-3.0	70.4
Худалдан авах ажиллагааны алба	384.8	374.5	-10.3	97.3
Бө. Архивын хэлтэс -	275.8	275.8	0.0	100.0
ДҮН	78,769.4	67,879.5	-10,889.9	86.2

Эх сурвалж: Аудитын судалгаа

Төсвийн гүйцэтгэл доогуур хувьтай гарсанд:

- Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөө 4,245.7 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байгууллагуудад санхүүжилт дутуу олгогдож гүйцэтгэл төлөвлөснөөс бага гарсан,
- Орон нутгийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалж санхүүжилт дутуу олгогдсон, зарцуулагдаагүй үлдэгдэл гарсан зэргээс шалтгаалж орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө бага гүйцэтгэлтэй гарсан,

- Сумуудын Хоршоог хөгжүүлэх сангуудын төлөвлөлтийг үндэслэлгүй хийсэн,
- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөсөн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл бүрэн хэрэгжээгүй, хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилт олгогдоогүй зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Соёл, спорт, аялал жуулчлалын газар, Орон нутгийн халамжийн сан, Хөгжимт драмын театр, Номын сан Архивын хэлтэс зэрэг байгууллагууд 99.1-100 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 111.4 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс 546.8 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 351.0 сая төгрөгийн, нийт 1,034.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого хүлээн авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Үүнээс урсгал зардалд 941.5 сая төгрөгийг зарцуулж 92.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Урсгал зардлын 67.9 хувийг буюу 639.2 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байна.

Аймгийн Засаг даргын ерөнхий дансны гүйцэтгэл

Аймгийн ерөнхий дансны төлөвлөгөө 2,152.2 сая төгрөг байна. Тайлант онд 1,991.2 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1,990.8 сая төгрөгийг зарцуулж 0.4 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Өмнөх онтой харьцуулахад аймгийн Засаг даргын ерөнхий дансны зарцуулалт 2,575.5 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №12 Аймгийн Засаг даргын ерөнхий дансны гүйцэтгэл (сая төгрөг)

Байгууллагын нэр	2024 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	2025 оны Гүйцэтгэл	Зөрүү
Аймгийн Засаг даргын ерөнхий данс	4,566.30	2,152.20	1,990.80	-2,575.50

Ахмадын хорооны ашиглалтын болон урсгал зардалд 187.9 сая төгрөгийг, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн ашиглалтын зардалд 228.9 сая төгрөгийг, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал, малын эмч нарт олгох вакцинжуулалтын хөлсөнд Мал эмнэлгийн газрын дансаар дамжуулан 452.6 сая төгрөгийг, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг улсын төсвийн байгууллагуудад олгох орон нутгийн нэмэгдэлд 1,121.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/64 дүгээр захирамжаар аймгийн Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүгчийн 130/ШШ2024/00440, 130/ШШ2024/00603 дугаартай шийдвэрүүдийг үндэслэж Цэнгэл сумын Засаг даргаар ажиллаж байсан А-гийн ажилгүй байсан хугацааны цалинд 30.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын ангилагдаагүй нөөц хөрөнгийн төсвөөс шилжүүлэн барагдуулсан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй байна. Шүүхийн шийдвэрээр төлсөн 30.1 сая төгрөгийг төсөвт нөхөн төлүүлэхээр албан шаардлага хүргүүлээ.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлант оны гүйцэтгэлд дараах залруулга хийгдлээ.

Залруулсан алдаа:

- Системийн алдаанаас шалтгаалж нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тайлант оны гүйцэтгэлд Засгийн газрын урсгал шилжүүлгийг 67.4 сая төгрөгөөр дутуу тайлагнаж ирүүлснийг залруулга хийлгэсэн.

2.2.2 Аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн байгууллагуудын орон тооны гүйцэтгэлийн талаар

Орон нутгийн төсвийн 8 байгууллага орон тоог 36-аар хэтрүүлсэн байна

Аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн 37 төсөвт байгууллагын орон тооны батлагдсан төлөвлөгөө 684, гүйцэтгэл 692 байна.

Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, аудитын алба, Орон нутгийн олон нийтийн радио, телевиз зэрэг байгууллагууд батлагдсан орон тоог баримталж ажилласан байна.

Хүснэгт№ 13 Орон нутгийн төсвийн байгууллагуудын орон тооны гүйцэтгэл

Аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн байгууллагууд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Аймгийн ИТХ	16	15	-1
Сумуудын ИТХ	46	48	2
Аймгийн ЗДТГ	92	101	9
Сумуудын ЗДТГ	410	422	12
Орон нутгийн өмчийн газар	6	6	0
Сум дундын ойн анги	9	11	2
Санхүүгийн хяналт, аудитын алба	9	9	0
Асрамжийн газар	10	11	1
Орон нутгийн олон нийтийн радио, телевиз	18	18	0
Байгаль орчны газар	37	35	-2
Худалдан авах ажиллагааны газар	6	8	2
Архивын хэлтэс	5	8	3
Дүн	664	692	28

Эх сурвалж: Аудитын судалгаа

Хүснэгт№ 14 Батлагдсан орон тоог хэтрүүлсэн байгууллагууд

№	Байгууллагын нэр	2025 оны	
		Төлөвлөгөө	Зөрүү
		Гүйцэтгэл	

1	Аймгийн ЗДТГ	92	101	9
2	Алтанцөгц сумын ЗДТГ	19	23	4
3	Ногооннуур сумын ЗДТГ	27	40	13
4	Ногооннуур сумын ИТХ	3	5	2
5	Сум дундын ойн анги	9	11	2
6	Асрамжийн газар	10	11	1
7	Худалдан авах ажиллагааны газар	6	8	2
8	Архивын хэлтэс	5	8	3
	Дүн	171	207	36

Батлагдсан орон тоог аймгийн ЗДТГ 9, Алтанцөгц сумын ЗДТГ 4, Ногооннуур сумын ЗДТГ 13, Ногооннуур сумын ИТХ 2, Сум дундын ойн анги 2, Асрамжийн газар 1, Худалдан авах ажиллагааны газар 2, Архивын хэлтэс 3 орон тоогоор буюу нийт 36 орон тоог хэтрүүлсэн байна

2.2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

Хэрэгжсэн боловч гүйцэтгэлийн баримт бичгийг ондоо багтаан ирүүлээгүй, зарим төсөл, арга хэмжээний санхүүжилт олгогдоогүйтэй холбоотой аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангууд 2,952.7 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө 9,395.6 сая төгрөг ба гүйцэтгэлээр 9,310.6 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Үүнээс 3,410.7 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн санд, 5,899.9 сая төгрөгийг сумуудын Орон нутгийн хөгжлийн санд хуваарилсан байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө 3,493.9 сая төгрөг, гүйцэтгэл 3,410.7 сая төгрөг оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 83.2 сая төгрөг байна. Сумуудын Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө 5,901.7 сая төгрөг, гүйцэтгэл 5,899.9 сая төгрөг ба дараа онд шилжих үлдэгдэл 1.8 сая төгрөг байна.

Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдээс зарим төрлийн ажил хэрэгжсэн боловч гүйцэтгэлийн баримт бичгийг ондоо багтаан ирүүлээгүй, зарим төсөл, арга хэмжээний санхүүжилт олгогдоогүй байна. Үүнтэй холбоотой 2025 оны жилийн эцсийн тайлангаар нийт 2,952.7 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн өглөг 1,048.9 сая төгрөг, сумуудын Орон нутгийн хөгжлийн сангийн өглөг 1,903.8 сая төгрөг байна.

Аудитаар сумуудын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 202.1 сая төгрөгийн зөрчил илэрч 2 албан шаардлага, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2,582.7 сая төгрөгийн зөрчил илэрч 819.3 сая төгрөгийн 1 зөвлөмж, 1,763.4 сая төгрөгийн 2 албан шаардлага өгсөн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Алтанцөгц сумын Орон нутгийн хөгжлийн санд нөөцийн өвсийг тараахдаа дээрх гаргасан шийдвэрийг зөрчиж 812 боодол өвсийг 8.8 мянган төгрөгөөр буюу 7,105 мянган төгрөгөөр бага үнээр худалдан борлуулж төсвийг үр ашиггүй зарцуулсан. Нийт тараасан 1140 боодол өвснөөс 100 боодол өвсийг малчдад хүлээлгэн өгсөн анхан шатны баримттай байна.

Цэнгэл сумын Орон нутгийн хөгжлийн сангаас дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн гэрээний дүн нь 10,0 сая төгрөгийн “Цэцэрлэгийг хөлдөөгчөөр хангах” ажлыг 2 ажил болгон босго үнэд багтаах зорилгоор төсөвт өртгийг хувааж, сумын Иргэдийн төлөөгчдийн хурлын тогтоолоор батлуулан, гэрээ шууд байгуулж гүйцэтгүүлсэн.
- Орон нутгийн хөгжлийн сангийн чиг үүрэгт хамааралтай боловч иргэдийн саналаар дэмжигдээгүй 180,0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлуулан, хэрэгжүүлсэн.
- Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн данснаас 2025 оны 7 дугаар сарын 07-ны өдөр “Актай” ХХК-нд баяр наадмын зардалд 5.0 сая төгрөг шилжүүлж, “Актай” ХХК-ны зарлагын баримтыг хавсаргасан боловч анхан шатны баримтуудыг бүрдүүлээгүй, зарцуулалтын тооцоо хийгээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрч албан шаардлага өгөгдсөн. Үүнд:

- Булган сумын Орон нутгийн хөгжлийн сангийн шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 39.1 хувьтай байна.
- Сагсай сумын Орон нутгийн хөгжлийн сангийн шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 68.3 хувьтай байна.
- Толбо сумын Орон нутгийн хөгжлийн сангийн шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 72.1 хувьтай байна.

2.2.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 7,151.1 сая төгрөг, гүйцэтгэл 6,997.5 сая төгрөг байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар боловсрол, эрүүл мэнд, соёлын салбаруудын их засварын ажилд 5,099.1 сая төгрөгийн, бусад хөрөнгө оруулалтын ажилд 2,052.0 сая төгрөгийн нийт 7,151.1 сая төгрөг төлөвлөсөн ба орон нутгийн орлогын бүрдэлтээс шалтгаалж санхүүжилтийн 82.9 хувь буюу 5,926.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан Сангийн яамнаас хөрөнгө оруулалтын холбогдолтой зардлуудыг тайлант оны сүүлийн саруудад хязгаарласантай холбоотой орон нутгийн хөрөнгө оруулалтын сангаас 5,416.2 сая төгрөгийг зарцуулж, 509.8 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл, 1,600.0 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын их засварын хөрөнгө оруулалтын ажлуудаас дутуу хэрэгжсэн төсөл арга хэмжээ байхгүй байна. Өмнөх оноос шилжиж ирсэн 7 төсөл арга хэмжээ, 2025 онд шинээр хэрэгжүүлэх 33 төсөл арга хэмжээ, нийт 4,837.4 сая төгрөгийн их засварын ажил хийгдсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлуудаас:

- Аймгийн төвийн Дотоодын цэргийн 829 дүгээр тусгай салбарт 2 ширхэг харуулын байр барих санхүүжилт хүрэлцээгүй тул 2026 онд шинээр төлөвлөгдсөн байна.
- Боловсролын байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангах ажил хэрэгжих боломжгүй тул хасагдсан байна.
- Аймгийн тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын тендер хойшлогдсоноос тухайн оны санхүүжилт олгогдоогүй байна.

2.2.5 Замын сангийн гүйцэтгэл

Замын сангийн 2025 оны батлагдсан төсөв 1,182.0 сая төгрөг ба үүний 1,052.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 129.4 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,052.6 сая төгрөгийн санхүүжилт авч урьд оны үлдэгдлээс 129.4 сая төгрөг, нийт 1,163.0 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 19.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Өлгий сумын авто замуудын нөхөөс хийх ажлыг “Жол” ХХК хийж гүйцэтгэсэн боловч улсын комисс хүлээж аваагүй байна.

БҮЛЭГ 3. ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ХЭРЭГЖИЛТ

3.1 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшин

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн, хүрэх үр дүн, зорилтот түвшин 86.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн ИТХ-ын 30 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-д заасныг үндэслэж аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх 21 хөтөлбөрийн хүрэх үр дүн, чанарын болон тоон үзүүлэлтийг 19 шалгуур үзүүлэлтээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 58 дугаар тогтоолоор 2025 онд хэрэгжүүлэх 21 хөтөлбөрийн хүрэх үр дүн, чанарын болон тоон үзүүлэлтийг 19 шалгуур үзүүлэлтээр хэвээр баталсан байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаанд хамаарах орон нутгийн өөрийн удирдлагын 2 хөтөлбөр, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт хамаарах орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 19 хөтөлбөрийг баталсан байна.

Аймгийн орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн 3 үзүүлэлтийн шалгуур үзүүлэлтээр үр дүнг тооцоход 100.85 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа хөтөлбөрийн хүрэх үр дүнг 2 шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн ба зорилтот түвшний биелэлт 101.7 хувьтай,

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнг 1 шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд, зорилтот түвшний биелэлт 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

-Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн зорилтот түвшин, хүрэх үр дүн 101.5 хувийн гүйцэтгэлтэй,

-Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх, орон нутгийн хэвлэл, мэдээллийн үйл ажиллагаа, ойжуулалт, хот байгуулалт, тохижилт, нийгмийн халамж, орон нутгийн төсөвт байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах хөтөлбөрийн зорилтот түвшин, хүрэх үр дүнг 100 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Дээрх хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнг:

-Орон нутгийн өмчийн харилцааны оновчтой бодлого, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх,

-Иргэд олон нийтийг өдөр тутмын мэдээ мэдээллээр хангах, төр засгийн бодлого, шийдвэрийг сурталчлан таниулах, орон нутгийн цаг үеийн асуудлыг ард иргэдэд шуурхай хүргэх,

-Ойн нөөц, биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, аймгийн хот, суурин газрыг тогтвортой хөгжүүлж, хотын иргэдийн одоогийн ба ирээдүйн эрүүл, аюулгүй байдлыг хангах, амьдрах таатай орчныг бүрдүүлсэн, өрсөлдөх чадвартай хот суурин газрыг бий болгох,

-Зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэх,

-СӨБ, ЕБС, ЭМТ, Соёлын байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, тогтмол зардлыг санхүүжүүлэх,

-Төрийн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, нээлттэй, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, дүгнэж, тайлагнах гэж тодорхойлсон ба энэ хүрээнд зорилтын биелэлтийг бүрэн хангасан гэж тайлагнасан байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, үйл ажиллагаа, орон нутгийн нөөц хөрөнгө, төрийн архив, албан хэрэг хөтлөлт, мэргэжлийн хяналт, зорилтот хөрөнгө оруулалт зэрэг хөтөлбөрийн хүрэх үр дүн, хэрэгжилт 90.0-99.5 хувьтай байна.

Автозам хөтөлбөрийн хүрээнд замын сангаас хэрэгжүүлсэн 46 нэр төрлийн замын ажлын биелэлт, хэрэгжилтийг 85.0 хувьтай гэж тайлагнасан байна.

БҮЛЭГ 4. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

4.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагуудын Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлж шалгасан. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил өмнөх оноос буурсан байна.

Аймгийн Засаг даргын харьяа төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 байгууллагад 7.0 сая төгрөгийн зөрчил илэрч 5.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 2.0 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн байна.

4.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил давтагдан гарч байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 14 төсвийн төвлөрүүлэн захирагч, 37 орон нутгийн төсөвт байгууллага, 29 орон нутгийн тусгай сан, орон нутгийн өмчийн 3 аж ахуйн нэгж, 3.1.5-т хамаарах төсвөөс санхүүжилт авдаг 4 өрхийн эмнэлэг, нийт 87 төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн цахим системд хамрагдаж, мэдээллээ байршуулсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хууль зөрчсөн нийт 4,945.6 сая төгрөгийн зөрчил илэрч 5 байгууллагад 3,755.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 9 байгууллагад 1,190.3 сая төгрөгийн зөрчилд 9 заалт бүхий зөвлөмж өгсөн байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Тус аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 10,298.2 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 4,638.7 сая төгрөгөөр бууруулж тодотгож баталсан байна.
2. Сангийн яамны хянасан дүнгээс орон нутгийн төсвийн суурь орлогыг 9,631.2 сая төгрөгөөр, төсвийн нийт зарлагыг 14,981.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.
3. Сангийн яамнаас зарим зардлын зарцуулах эрхийг хязгаарласан, орон нутгийн төсвийн суурь орлого тасарсантай холбоотой төсвийн зарлагын гүйцэтгэл 10,889.8 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна.
4. Аймгийн ТЕЗ-ийн харьяа 8 байгууллага батлагдсан орон тоог 36-гаар хэтрүүлсэн байна.
5. Хэрэгжсэн боловч гүйцэтгэлийн баримт бичгийг ондоо багтаан ирүүлээгүйгээс санхүүжилт олгогдоогүй аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан 2,952.7 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.
6. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн, хүрэх үр дүн, зорилтот түвшин 86.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

I. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА /Е.ЗАНГАР/-Д:

1. Батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажиллах;
2. Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангууд оны эцэст олгогдоогүй санхүүжилтийн улмаас өглөгтэй гарч төсвийн гүйцэтгэл доогуур гарахад нөлөөлж байгаа асуудалд анхаарах;

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу аудитын тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 онь 07 сарын 20 өдөр

Дугаар А/10.

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргад хүргүүлсүгэй.

3.Аудитын ажлын болон нотлох баримтыг ажлын 7 хоногийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын багт үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (Д.Назгүл)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОВЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ЖЕНИСБЕК



830001000019

ХАВСРАЛТ:

Хавсралт №1

Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(сая төгрөг)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,769.3	67,879.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,784.5	52,958.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,045.5	51,471.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,146.4	22,193.5
210101	Үндсэн цалин	11,785.7	11,511.4
210102	Нэмэгдэл	9,181.3	8,703.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	556.3	572.9
210104	Урамшуулал	1,475.9	1,257.3
210105	Гэрээт ажлын хөлс	147.2	148.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,938.1	2,925.3
210201	Тэтгэврийн даатгал	2,022.9	2,004.2
210202	Тэтгэмжийн даатгал	228.8	230.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	114.9	115.8
210204	Ажилгүйдлийн даатгал	114.6	115.0
210205	Эрүүл мэндийн даатгал	457.0	459.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,794.8	16,815.7
210301	Гэрэл, цахилгаан	1,706.8	1,539.2
210302	Түлш, халаалт	13,961.0	13,227.0
210303	Цэвэр, бохир ус	1,017.3	979.0
210304	Байрны түрээс	1,109.7	1,070.5
2104	Хангамж, бараа материалын зардал	951.5	709.9
210401	Бичиг хэрэг	126.3	72.1
210402	Тээвэр, шатахуун	658.5	515.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	123.7	101.5
210404	Ном, хэвлэл	0.2	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9.8	2.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33.0	18.3
2105	Нормативт зардал	290.1	220.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	205.5	175.9
210502	Хоол, хүнс	45.0	25.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	39.6	19.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	930.4	702.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	107.7	52.8
210602	Тавилга	28.0	12.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2.5	0.8
210604	Урсгал засвар	792.2	636.3

2107	Томилолт, зочны зардал	376.2	251.0
210702	Дотоод албан томилолт	331.8	235.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	44.3	15.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,099.7	2,566.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,006.9	2,534.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9.4	0.9
210803	Даатгалын үйлчилгээ	21.7	2.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	8.1	1.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2.9	0.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43.8	24.9
210807	Газрын төлбөр	4.1	0.6
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.5	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2.3	0.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,518.3	5,087.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,417.9	5,055.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100.4	31.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,739.0	1,486.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,153.6	1,025.2
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,153.6	1,025.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	585.4	461.3
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	58.5	58.5
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	97.0	68.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	275.1	247.1
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	103.4	67.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51.6	19.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,984.8	14,921.0
2200	Дотоод эх үүсвэрээр	19,984.8	14,921.0
220001	Барилга байгууламж	4,186.1	3,017.1
221001	Их засвар	7,130.1	4,793.6
222001	Тоног төхөөрөмж	1,462.6	1,056.4
223001	Бусад хөрөнгө	7,206.1	6,053.9
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	78,769.3	67,516.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,102.3	37,856.5
132001	Орон нутгийн төсвөөс	42,102.3	37,856.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,844.9	987.4
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,124.3	911.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	75.4
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	5,785.5	-
123	УЛСЫН ТӨСӨВ ОРОН НУТГИЙН ТӨСӨВ ХООРОНДЫН ШИЛЖҮҮЛЭГ	28,757.1	28,672.1
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	9,395.6	9,310.6
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	19,361.5	19,361.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		7,496.0

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		7,132.5
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	37	36
610001	Төсвийн байгууллага	37	36
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	664	692
620001	Удирдах ажилтан	173	172
620002	Гүйцэтгэх ажилтан	302	289
620003	Үйлчлэх ажилтан	137	169
620004	Гэрээт ажилтан	52	62
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	664	692
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	261	275
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4	4
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	2	3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	198	206
650010	Гэрээт ажилтан	52	62
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	147	141
66	Нийт тэтгэвэрт гарагч	7	7
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	5	3
660002	Боловсролын тухай хуулиар тэтгэвэрт гарагч	-	2
660005	Хөдөлмөрийн тухай хуулиар тэтгэвэрт гарагч /Бусад/	2	2

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2025 оны нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл

(сая төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,034.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	941.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	941.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	79.80
210101	Үндсэн цалин	49.38
210102	Нэмэгдэл	10.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10.54
210104	Урамшуулал	7.32
210105	Гэрээт ажлын хөлс	1.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5.49
210201	Тэтгэврийн даатгал	5.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4.94
210301	Гэрэл, цахилгаан	4.15
210302	Түлш, халаалт	0.79
2104	Хангамж, бараа материалын зардал	96.54
210401	Бичиг хэрэг	2.25
210402	Тээвэр, шатахуун	60.41
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4.18
210404	Ном, хэвлэл	5.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22.34
2105	Нормативт зардал	2.04
210502	Хоол, хүнс	1.62
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.42
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	91.26
210601	Багаж, техник, хэрэгсэл	27.33
210602	Тавилга	12.60
210604	Урсгал засвар	51.33
2107	Томилолт, зочны зардал	6.83
210702	Дотоод албан томилолт	6.83
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15.06
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	639.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	636.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	92.80

213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	92.80
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,034.26
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,034.26
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	25.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	111.44
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	546.78
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	351.04
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан